НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ
Нийслэлийн Засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7799 0101
Цахим шуудан: ubhd@emg.ub.gov.mn
Цахим хуудас: www.ubhealth.mn

2024.09.02 № 10-13-02/021/1426

"СМАРТ ПРОЖЕКТ ХХК-Н ЗАХИРАЛ
С.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

Зураг төсөлд эрүүл ахуйн
хяналт хийсэн тухай

Тус газарт ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн 4.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газрын даргын баталсан "Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, зураг төсөл зохиох, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийх тухай" 10-00/02 дугаартай удирдамжийг үндэслэн Баянгол дүүргийн ерөнхий боловсролын 13-р дунд сургуулийн 640 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилгын ажлын зураг төсөлд 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр эрүүл ахуйн хяналт хийлээ.

Зураг төсөл боловсруулсан байгууллагын нэр, зураг төслийн нэр, үе шат

Нийслэлийн ерөнхий архитекторын баталсан 2024 оны 2024/00-075 дугаар бүхий архитектор төлөвлөлтийн даалгавартай.-Боловсрол, шинжлэх ухааны яамны төрийн нарийн бичгийн даргын баталсан 2023 оны 04 сарын 17-ны өдрийн зургийн даалгавартай. Батлагдсан загвар зурагтай. Ерөнхий төлөвлөгөө, барилга архитектур, барилга бүтээцийн ажлын зургийг "Смарт прожект" ХХК- д 2024 онд боловсруулсан. ЕТ, БА- зургийн шифр СП-01/2024.

Барилга байгууламж барих газрын зөвшөөрөл:

Баянгол дүүргийн ерөнхий боловсролын 13 дугаар сургуульд баянгол дүүргийн 13 дугаар хороонд 2.0168га газрыг сургалтын зориулалтаар 15 жилийн хугацаатай олгосон Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн 000002000 дугаартай гэрчилгээтэй. Нэгж талбарын дугаар 1680501000

Барилгын давхрын байгуулалт:

Тус сургуулийн барилга нь 3 блок бөгөөд зоорьгүй 3 давхар төмөр бетон барилга. Гадна эдэлбэр газарт амралтын бүс, спорт талбай төлөвлөсөн.

Нэгдүгээр давхарт гонх, үүдний танхим, өлгүүр, шатны хонгил, коридор, туслах өрөөтэй 1 анги, биологийн кабинет, бага ангиуд, номын фондын өрөөтэй, уншлагын танхим, эрэгтэй, эмэгтэй хөдөлмөрийн кабинет, багш нарын өрөө, агуулах, шүршүүр, ариун цэврийн өрөөтэй эрэгтэй, эмэгтэй хувцас солих арын өрөөтэй гаднаас орох хаалгатай биеийн тамирын заал,

1550111354

гадагш хаалга, ариун цэврийн өрөөтэй тусгаарлах өрөө бүхий эмчийн өрөө, хүнсний 2 агуулах, ажилчдын хувцас солих өрөө, хооллох заал бүхий гал тогоо, эрэгтэй, эмэгтэй сурагчдийн ариун цэврийн өрөө, багш ажилчид, ХБИ-ний ариун цэврийн өрөө төлөвлөсөн,

2 дугаар давхарт шатны хонгил, завсарлах талбай, туслах өрөөтэй, химийн кабинет, хичээлийн танхимууд, архивын өрөө, багш нарын өрөө, тайзны арын өрөө, эрэгтэй, эмэгтэй сурагчид, ажилчдын ариун цэврийн өрөө болон цэвэрлэгээний хэрэгслийн өрөө төлөвлөсөн,

3 дугаар давхарт шатны хонгил, завсарлах талбай, 9 хичээлийн танхим, тайз бүхий урлаг заал, албан өрөө, эрэгтэй, эмэгтэй сурагчид, ажилчдын ариун цэврийн өрөө болон цэвэрлэгээний хэрэгслийн өрөө төлөвлөсөн байна.

Барилгын халаалт, агаар сэлгэлт:

Сургуулийн ангиуд, бие засах газар агаар сорох ердийн агааржуулалттай, хурлын заал, хооллох танхим, номын сангийн уншлагын заал, гал тогооны халуун боловсруулалтын өрөөнд цэвэр агаар оруулах, бохир агаар сорох механик төхөөрөмжтэй байхаар төлөвлөсөн байна.

Мэдээлэл холбоо сүлжээ ХХК-ийн B-U2024/585 дугаартай техникийн нөхцөлтэй.

Цахилгаан хангамж :"УБЦТС" ТӨХК-н 2024 оны 01/03091/24 дугаартай техникийн нөхцөлтэй. Дулаан хангамж: "УБДТС" ТӨХК-ийн 2024 оны 277/2024 дугаартай техникийн нөхцөлтэй, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2024 оны 2024/52 дугаартай техникийн тодруулгатай.

"Жоншт-Уул" ХХК-д 2023 онд хийлгэсэн №ЗТ16-366/22 дугаартай инженер геологийн судалгаагаар инженер геологийн дунд зэргийн нөхцөлтэй. Суурийг нээсний дахин дахин хяналт хийлгэх шаардлагатай.

Дүгнэх нь:

Баянгол дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын 13 дугаар дунд сургуулийн 640 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилгын ажлын зураг төслийг хянахад Монгол Улсын Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 211 дүгээр тушаалаар батлагдсан Ерөнхий боловсролын сургуулийн барилга төлөвлөлт-д тусгагдсан эрүүл ахуйн нормын шаардлагад нийцэж байна.

Улсын байцаагчийн гаргасан дүгнэлтийг үндэслэлгүй гэж үзвэл Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтыг үндэслэн гомдол гаргах эрхтэй.

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН
ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ М.НЭРГҮЙ

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
10-13-02/021

ХҮЛЭЭН АВСАН:
ЗАХИРАЛ С.ЛХАГВАСҮРЭН